

5

**БҮС НУТАГ ДАХЬ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУДЫГ СУДЛАХ НЬ**

Ц.Бямбадорж

Шилжих хөдөлгөөн нь хүн ам байнга оршин суух газраа засаг захиргааны нэгж хооронд сэлгэн, өөрчлөх үйл явц юм. Шилжих хөдөлгөөнийг нас, хүйс, боловсрол, орлого, гэрлэлтийн статус гэх мэт ялгавартай түвшнээр судлах зайлшгүй шаардлагатай байдаг. Хөгжингүй орны хувьд хүний физиологи, эрүүл ахуйн нөхцөл шилжих хөдөлгөөнд нилээд зонхилох нөлөө үзүүлж байгаагаас шилжилт хотоос хөдөө рүү, хотоос хот руу гэсэн чиглэл давамгайлах хандлагатай байна. Харин хөгжиж буй орнуудын хувьд шилжих хөдөлгөөнд хамрагдах үндсэн шалтгаан нь амьдралын нөхцөл, байдал, орлогын түвшин гэх зэрэг болно. Тийм ч учраас хөдөөнөөс хот руу илүү олон хүн нүүх үзэгдэл ажиглагддаг. Шилжих хөдөлгөөнд оролцоход нийгэм, эдийн засаг, соёл, байршил гэх мэт олон хүчин зүйл нөлөөлнө. Хүн ам зүйн судалгаа, шинжилгээний ажлуудад шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг голдуу макро түвшинд судалдаг байсан бол, харин сүүлийн жилүүдэд хувь хүмүүсийн зан үйлтэй холбон судлах болсон.

Бүс нутгуудын хувьд нийт ажиллах хүчний буюу ажиллагсад болон ажилгүйчүүдийн ихэнх хувийг 5 насны интервалаар авч үзэхэд 16-44 насныхны эзлэх хувийн жин өндөр байна. Үүнийг бусад бүс болон улсын дүнтэй харьцуулбал баруун бүсийн нийт аймгуудын хувьд эдгээр насны ажиллах хүчний өөрчлөлтийн чиг хандлага адил байна.

2006 оны байдлаар нийт ажиллагсдын дийлэнх хувийг буюу талаас илүү хувийг хөдөө аж ахуйн ажилчид /55.2%/, энгийн ажил гүйцэтгэгчид /19.7%/, үйлчилгээний ажилтан ба дэлгүүр, зах зээл дээр худалдаа эрхлэгчид /8.6%/ тус тус эзэлж байна. Иймд хөдөө орон нутагт боловсрол багатай хэсэг ажиллаж байна. Мөн ажиллагсдыг ажил мэргэжлийнх нь хувьд бүтцийн өөрчлөлтийг сүүлийн хоёр жилээр авч үзэхэд мэргэжилтэн 0.13%-иар, инженер техникийн ажилтан 0.2%-иар, ХАА, загас ан агнуурын ажилчид 2.2%-иар тус тус нэмэгдсэн байхад бусад мэргэжлийн ажилчид тодорхой хувиар буурсан байна. Дээрх мэргэжлийн ажилчдын авч буй цалингийн ялгаанд дараах байдал ажиглагдаж байна. Баруун бүс нутагт ажиллагсдын дийлэнх хувийг эзэлдэг ХАА, энгийн ажил эрхэлдэг ажилчдын авч буй цалин нь бусад мэргэжлийн ажилчдын авч буй цалингаас харьцангуй бага байна. Иймд баруун бүсийн хүн амын орлого бага гэдэг.

Ажиллагсдыг өмчийн харьяалаар авч үзвэл: хувиараа хөдөлмөр эрхлэгчид /75.3%/, төрийн төсөвт байгууллага /13.3%/, ХХК /3.8%/, хоршоо /2.3%/, ХК /2.2%-ын ажиллагсад эзэлж байна. 2006 оны байдлаар ажиллагсдыг 2003 он /суурь он/-той харьцуулахад хувиараа хөдөлмөр эрхлэгчид /1.2%/, төрийн төсөвт байгууллага /1.3%/, ХХК /0.5%/, төрийн бус байгууллага /0.2%-р тус тус өссөн байхад бусад өмчийн харьяалалд ажиллагсад буурсан байна. Үүнээс үзэхэд баруун бүсийн нийт ажиллагсдын дийлэнх хувь нь хувийн хэвшилд ажиллаж, тэдний тоо жил бүр тасралтгүй өсч байгаа тул төр, засгаас явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг түлхүү хэрэгжүүлбэл бүс нутгийн хөгжил болон ажиллагсдын хувьд тоо, чанарын өөрчлөлт гарах ба шилжилт хөдөлгөөнийг сааруулах томоохон бодлого болно гэж үзэж байна. “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоо, фермерийн аж ахуй байгуулах, аялал жуулчлал хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийг бүх талаар дэмжинэ.”¹⁰

Баруун бүсийн ажиллагсдыг боловсролын түвшингээр авч үзэхэд тухайн бүс нутагт нийт ажиллагсдын дийлэнх хувийг бүрэн дундаас бага боловсролтой, үлдсэн хэсгийг техникийн мэргэжилтнээс дээш боловсролтой хүмүүс эзэлж байна. Ажиллагсдын боловсролын байдлыг 2006 оныг 2005 онтой харьцуулж үзэхэд дээд боловсролтой хэсэг 0.7%-иар, тусгай мэргэжилийн бүрэн бус дээд боловсролтой хэсэг 0.5%-иар өссөн үзүүлэлттэй байхад бусад боловсролтой ажиллагсад буурсан байна. Баруун бүсийн төрийн албан хаагчийн боловсрол 2005 онд: тусгай дунд, бүрэн дунд түвшний боловсролтой хүмүүс нийт албан хаагчдын 50 гаруй хувийг эзэлж байгаа нь төрийн албан хаагчдын боловсролын түвшин доогуур байна. Иймд баруун бүсэд боловсрол багатай ажилчид нийт ажиллагсдын ихэнх хувийг эзэлж байна.

¹⁰ Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр, 2006-2015 он

Баруун бүсийн нутгийн ажиллагсдыг эдийн засгийн салбарт эзэлж буй хувь, хэмжээгээр авч үзэхэд нийт ажиллагсдын ихэнх хувь нь ХАА, байгаль орчин /67,8%/, худалдаа /8.1%/, дэд бүтэц /2.3%/, барилга /2.0%/, зочид буудлын үйлчилгээ /0.7%/-ний салбарт тус тус ажиллаж байна. Энд онцлон тэмдэглэхэд аж үйлдвэрийн салбарт нийт ажиллагсдын дөнгөж 1.5% ноогдож байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм. Энэ нь тус бүс нутгийн эдийн засгийн салбарын бүтэц дэндүү хоцрогдолд орж, гаж байдал бий болсныг илтгэн харуулж буй хэрэг юм.

Бүс нутгуудын хувьд ажилгүйдлийн түвшин буурах хандлагатай байгаа хэдий ч баруун бүсийн ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр, сүүлийн гурван жилийн хувьд өссөн байна. Энэ нь баруун бүсэд ажилгүй хүний тоо өндөр байгааг харуулж байна. Иймд тус бүс нутаг дахь ажиллах хүчний дийлэнх хувийг 16-44 насны залуучууд эзэлж байсан бөгөөд тэднийг ажлын байртай болгоход чиглэгдсэн бодлого авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ажилгүйчүүдийг боловсролын байдлаар нь авч үзэхэд тус бүсийн нийт ажилгүйчүүдийн дийлэнх хувийг боловсрол багатай иргэд эзэлж байна. Тиймээс эдгээр боловсрол багатай иргэдэд чиглэгдсэн боловсрол болон мэргэжлийн чиг баримжаа олгож буй сургалт явуулах шаардлагатай байна.

2005 оны байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийг мэргэжлийн байдлаар авч үзэхэд ажил хайж байгаа хүмүүсийн ихэнх хувийг үйлдвэр /9.1%/, ХАА /7.5%/, барилга /5.5%/, боловсрол /6.3%/-ын чиглэлээр бүртгүүлсэн байна. Иймд эдгээр чиглэлийн ажлын байрыг нэмэгдүүлж чадвал тухайн ажилгүйчүүдийг ажиллагсдын эгнээнд шилжүүлэх боломж бүрдэнэ.

Шилжих урсгал нь 1993-1999 он, 2001-2004 онуудад нэмэгдэх хандлагатай байсан ч 2004 оноос эхлэн буурах хандлагатай байна. Харин 1999-2001 онуудын хоорондох шилжих хөдөлгөөний бууралт хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжин суурьшихад төлбөр төлдөг байсан дүрэм, журамтай холбоотой. Гэвч энэ байдал удаан үргэлжлээгүй, учир нь 2002 оноос дээрх шилжилтийн эсрэг авч хэрэгжүүлж байгаа бодлогыг Монгол улсын үндсэн хуулийг зөрчиж байна гэсэн үндэслэлээр хүчингүйд тооцсонтой холбоотой юм.

Шилжигсдийг насны бүлгээр авч үзвэл: нийт шилжигсдийн дийлэнх хувийг 15-39 насныхан эзэлж байна. Мөн түүнчлэн баруун бүсийн ажиллах хүчинд гол байр суурийг эзэлж буй хэсэг шилжих хөдөлгөөнд түлхүү орж байна. Үүнээс үзэхэд шилжилт хөдөлгөөнд эдийн засгийн идэвхтэй хэсэг нь түлхүү хамрагдаж байна.

График 1. Шилжих хөдөлгөөний судалгаа.



Хүснэгт 1. Шилжигсдийг насны бүлэг, хүйсийн харьцаагаар авч үзсэн судалгаа.

Шилжиж явсан нийслэл, аймаг	Нийт шилжигсэдэд 15-39 насныхны эзлэх хувь			15-39 насны шилжигсэдэд эзлэх хувь хүйсээр		15-39 насны шилжигсэдэд эзлэх хувь хүйсээр		15-39 насны шилжигсэдэд эзлэх хувь хүйсээр	
	2004 он	2005 он	2006 он	2004 он (эр)	2004 он (эм)	2005 он (эр)	2005 он (эм)	2006 он (эр)	2006 он (эм)
Баян-Өлгий	50.15	49.88	56.53	50.96	49.03	48.8	51.2	48.89	51.10
Говь-Алтай	65.7	64.95	68.29	47.80	52.19	46.74	53.25	47.36	52.63
Завхан	60.34	61.30	59.60	49.32	50.67	50.04	49.95	47.87	52.12
Увс	60.17	60.55	61.84	49.77	50.22	48.65	51.34	53.68	46.31
Ховд	60.23	61.08	61.14	47.44	52.55	49.42	50.57	51.01	48.98

Эх сурвалж: Судлаачийн тооцоогоор

Хүснэгт 2. Баруун бүсийн нийт ажиллах хүчний насны бүтцийн судалгаа. 2006 он

Бүс	Насны интервалаар										
	< 16	16-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60+
Баруун бүс	0.078	9.89	15.45	16.33	15.92	14.24	11.34	8.6	5.2	2.8	0.36
Хангайн бүс	0.015	10.76	15.65	15.15	15.01	13.4	11.71	9.3	5.5	2.6	0.88
Төвийн бүс	0.065	8.77	15.15	15.49	14.93	13.69	12.11	9.5	6.0	3.2	1.16
Зүүн бүс	0	8.72	15.66	16.5	15.46	14.03	12.21	9.7	5.2	2.7	0
Улаанбаатар	0.065	5.15	11.74	14.82	16.08	14.99	13.4	11.4	7.7	4.3	0.29
Улсын дүн	0.051	8.16	14.16	15.39	15.56	14.19	12.35	10.0	6.3	3.3	0.57

Эх сурвалж: Судлаачийн тооцоогоор

Баруун бүсийн хүн ам зүйн ачааллыг төв суурин газрын хотуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Энэ нь шилжилт хөдөлгөөнөөс үүдэн тухайн бүс нутагт нэг тэжээгчид оногдох тэжээлгэгчийн тоо өндөр байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, бүс нутгийн хөгжлийг тодорхойлогч гол хэсэг шилжилт хөдөлгөөнд хамрагдаж байгаа нь анхаарал татаж байна.

Шилжих хөдөлгөөн ба хүний хөгжлийн индексийн хамаарал. Хүний хөгжлийн индекс нь эрүүл саруул байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжээсийг авч үздэг. Тиймээс энэ индексийн эрүүл саруул, урт удаан насалтыг илэрхийлэх дундаж насалт, мэдлэгийн түвшинг илэрхийлэх насанд хүрэгсдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин болон бага, дунд, дээд сургуульд хамрагдалт, амьжиргааны зохистой түвшинг хангахад шаардагдах нөөцийг илэрхийлэх нэг хүнд ногдох бодит ДНБ гэсэн үзүүлэлтүүд нь баруун бүс нутгийн хувьд харьцангуй доогуур үзүүлэлттэй байгаа тул шилжих хөдөлгөөний учир шалтгаан болж, шилжих хөдөлгөөний “татах, түлхэх хүчин зүйл”-ийн онолын үндэслэл болж байна.

Тиймээс “татах хүчин зүйл”-ийн онолоор шилжих хөдөлгөөн дараах байдлаар тайлбарлагдаж байна.

1. Хот болон баруун бүсийн боловсролын индексийн зөрүү их байгаа нь татах хүчин зүйлийн онолын “соёл, боловсролын өндөр хангамж” гэсэн хүчин зүйлийн нөлөөгөөр хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн бий болж байна.
2. Хөдөөгийн бүс нутагт нэг хүнд ноогдох ДНБ бага, ажилгүйдлийн түвшин өндөр байгаа явдал нь татах хүчин зүйлийн онол дахь “хот дахь техник технологийн дэвшил, ажил эрхлэх боломж” гэсэн нөхцөлийг иш үндэс болгон шилжилт хөдөлгөөнд ихээхэн хэмжээгээр хамрагдаж байна.
3. Эрүүл саруул, урт удаан насалтыг илэрхийлэгч дундаж насалт хөдөөгийн бүс нутагт бага, хотод өндөр байгаа явдал “хөдөөгийн эрүүл мэндийн үйлчилгээнд чиглэгдсэн улс төрийн бодлогын хэрэгжилт хангалтгүй” гэсэн түлхэх хүчин зүйлийн нөхцөлтэй уялдаатайгаар шилжилт хөдөлгөөн бий болж байна.

Хэдийгээр дээрх хүчин зүйлүүд нэг талаас харахад татах хүчин зүйлээр тайлбарлагдаж байгаа хэдий ч нөгөө талаас тухайн хүчин зүйлийг харахад тэр үзүүлэлт нь түлхэх хүчин зүйл болж байгааг мөн анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, дээр онолын хувьд шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй хүчин зүйлсийг “хөгжлийн дорой байдал” гэж үзсэнээр ХХИ баруун бүсэд бага байгаа нь хөгжлийн дорой байдлыг харуулж, шилжих хөдөлгөөн бий болох шалтгаан болж байна.

Шилжих хөдөлгөөний “татах, түлхэх хүчин зүйлийн онол” дээр үндэслэсэн эконометрик үнэлгээ: Шилжилт хөдөлгөөнийг хүний хөгжлийн индексийн үзүүлэлт буюу “нэг хүнд ногдох ДНБ-ий индекс”, “хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс”, “дундаж наслалтын индекс”-ээс тус бүрээс хамааруулан эконометрик аргаар өгөгдлийг панел хэлбэрээр оруулж үнэлсэн. (Үнэлгээний үр дүнг хавсралтаас харж болно).

Үнэлгээний үр дүнгээс харахад баруун бүсийн шилжилт хөдөлгөөн нь “нэг хүнд ногдох ДНБ-ий индекс”-ээс урвуу, “хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс”-ээс эерэг, “дундаж наслалтын индекс”-ээс урвуу хамааралтай байна. Үүнийг дараах байдлаар тайлбарлаж байна.

1. “Нэг хүнд ногдох ДНБ-ий индекс”-ээс урвуу хамааралтай байгаа нь тухайн бүс нутагт үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үүгээр дамжуулан ажил эрхлэлтийг нэмэгдүүлэн ажилгүйдлийг багасгаж, хүн амын амжиргааг дээшлүүлэх нь шилжих хөдөлгөөнийг бууруулах нэг шалтгаан болж байна. Тодруулбал, хэрвээ бусад үл хамаарах хувьсагчид тогтмол үед “нэг хүнд ногдох ДНБ”-ий индекс” 0.001 пунктээр нэмэгдэхэд шилжих хөдөлгөөнд хамрагдах хүний тоо 8 хүнээр буурна гэдгийг тэгшитгэлээс харж болох юм. (ХХИ-д үзүүлэлтийг тэг мянганы нарийвчлалаар тооцсон тул өөрчлөлтийн үр дүнг 0.001-ээр тооцов. Мөн дараах хоёр үл хамаарах хүчин зүйлсийн өөрчлөлтөөс шилжилт хөдөлгөөнийг хамааруулан тооцохдоо дээрх хэлбэрээр тооцно.)
2. “Хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс”-ээс эерэг хамааралтай байгаа нь сүүлийн жилүүдэд дээд боловсрол эзэмших сонирхолтой болсон залуучуудын тоо эрс нэмэгдсэн ба ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдийн ихэнх хувь нь их, дээд сургуульд суралцаж байна. Энэ суралцах үйл явц ихэвчлэн Улаанбаатарт явагддаг болохоор дээд мэргэжил эзэмших зорилгоо хэрэгжүүлэхийн тулд тэдний зарим хэсэг нь шилжих хөдөлгөөнд оролцож байгаа байдал дээрх үр дүнтэй холбоотой. Мөн үүнээс гадна эцэг, эхчүүд хүүхдийнхээ ирээдүйн боловсролд анхаарч, шилжих хөдөлгөөнд оролцдог гэдэг нь бусад судалгаагаар тайлбарлагдсан.

Тодруулбал, хэрвээ бусад үл хамаарах хувьсагчууд тогтмол байх үед энэ үзүүлэлт 0.001 пунктээр нэмэгдэхэд шилжих хөдөлгөөнд оролцох хүний тоо 19 шилжигчээр нэмэгдэх болно гэдгийг үнэлсэн тэгшитгэлээс харж болно. Боловсролын түвшин нэмэгдэх тусам шилжилт нэмэгддэг.¹¹ Тиймээс баруун бүсийн боловсролын түвшин нэмэгдэх тусам шилжих хөдөлгөөн нэмэгдэж байна. Энэ нь баруун бүсийн шилжилт хөдөлгөөнийг бууруулахын тулд боловсролын түвшинг бууруул гэсэн үг биш юм.

Шилжилт хөдөлгөөн ба ажиллах хүчний өртгийн хамаарлын шинжилгээ. Харрис-Годарогийн шилжилтийн загварын дагуу хот болон хөдөөгийн цалингийн зөрүү нь хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн үүсэх томоохон

¹¹ Хүн ам зүйн асуудлууд, сурах бичиг, Улаанбаатар, 2006 он, X-81

шалтгаан болж байна. Энэ нь шилжигчдийн хувьд өрхийн орлогоо нэмэгдүүлэх буюу амьжиргаагаа дээшлүүлэх гол арга юм. Үүнээс гадна бүс нутгийн ажиллагсдыг боловсрол болон мэргэжилтэй нь холбон цалингийн түвшний ялгаатай байдлыг авч үзвэл, бүс нутгийн нийт ажиллах хүч буюу ажиллагсад болон ажилгүйчүүдийн ихэнх хувь нь боловсрол багатай; мөн ажиллах хүчний ажиллаж буй салбар болон тэдний авч байгаа цалингийн ялгаанаас үзэхэд баруун бүсийн нийт ажиллагсдын дийлэнх хувийг ХАА, энгийн ажил эрхэлдэг ажилчид эзэлдэг; тэдний авч буй цалин нь бусад мэргэжлийн ажилчдын цалингаас харьцангуй доогуур; мөн Улаанбаатарын ижил мэргэжилтний авч буй цалингаас бага байгаа нь тухайн бүс нутгийн ажиллах хүчийг шилжих хөдөлгөөнд түлхүү оруулах шалтгаан болж байгаа болов уу? гэж таамаглаж байна.

Дээрхээс гадна ажиллагсдын цалинг байгууллагын өмчийн харьяаллаар ялган авч үзэхэд нийт ажиллагсдын дийлэнх хувь нь хувийн хэвшилд (төрийн төсөвт байгууллагаас гадна) өөрөөр хэлбэл, ХХК, Хоршоо, ХК-д ажиллаж байгаа ба тэдгээрийн авч буй цалинг бусад өмчийн хэлбэртэй харьцуулахад боломжийн байгаа тул төр, засгаас явуулж буй жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг баруун бүсд түлхүү хэрэгжүүлбэл шилжилт хөдөлгөөнийг сааруулах томоохон бодлого болно гэж үзэж байна.

“Татах, түлхэх хүчин зүйл”-ийн онол дээр үндэслэсэн баруун бүсийн шилжих хөдөлгөөний эконометрик үнэлгээнээс харахад:

1. “Нэг хүнд ногдох ДНБ-ий индекс”-ээс урвуу хамааралтай байгаа нь баруун бүс нутагт үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үүгээр дамжуулан ажил эрхлэлтийг нэмэгдүүлэн ажилгүйдлийг багасгаж, хүн амын амьжиргааг дээшлүүлэх нь шилжих хөдөлгөөнийг бууруулах нэг үндэслэл болно. Энэ үндэслэлийг дээр Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан байдалтай холбон авч үзсэн. Хэрвээ энэ хөтөлбөрийн үйл ажиллагаа хөтөлбөрийн дагуу амжилттай хэрэгжвэл баруун бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэн түүгээр дамжуулан ажилгүйдэл багасч, хүн амын амьжиргааны түвшин нэмэгдсэнээр бүсийн харьцангуй хоцрогдлыг богино хугацаанд даван гарч, бүс нутгийн хүн ам төрж өссөн нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин бүрдэж, шилжих хөдөлгөөнийг бууруулах томоохон нөхцөл болж өгнө.
2. Онолын хувьд авч үзэхэд боловсролын түвшин нэмэгдэх тусам шилжилт хөдөлгөөн нэмэгддэг гэсэн үндэслэлтэй. Судалгааны ажлын эконометрик үнэлгээний хувьд “хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс”-ийн хувьсагчийн утга онолын үндэслэлтэй нийцэж байна. Энэ нь сүүлийн жилүүдэд дээд боловсрол эзэмших сонирхолтой болсон залуучуудын тоо эрс нэмэгдсэн ба ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдийн ихэнх хувь нь их, дээд сургуульд суралцаж байгаатай холбоотой. Гэхдээ энэ нь шилжих хөдөлгөөнийг бууруулахын тулд бүс нутгийн боловсролын түвшинг бууруулна гэсэн үг биш юм. Бүс нутгийн боловсролын түвшинг

нэмэгдүүлэхийн тулд баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгай бодлогууд тусгагдсан байдаг.

3. “Дундаж наслалтын индекс”-ээс урвуу хамааралтай байгаа шалтгаан нь тухайн бүс нутаг аймгуудын эрүүл мэндийн байгууллагын боловсон хүчин, үйлчилгээ, чанар, хүртээмж муу гэдгээр тайлбарлаж болох юм. Өөрөөр хэлбэл, бүс нутгийн эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах нь шилжилт хөдөлгөөнийг бууруулах бас нэг үндэс болж өгнө. Энэ утга санааг баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгасан байдаг бөгөөд үүний талаар авч хэрэгжүүлэх бодлогуудыг мөн тусгасан байдаг.

Ажиллах хүч ба шилжигсдийн насны бүлгээр авч үзсэн судалгааг харьцуулан үзэхэд:

1. Шилжих хөдөлгөөнд ажиллах хүч түлхүү оролцож байна гэдэг нь харагдаж байна. Ажиллах хүчний оролцооны түвшин (72.69%) өндөр байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын дийлэнх хэсэг ажиллах хүчинд хамаарагдаж байгаа буюу тэр хэсэг шилжих хөдөлгөөнд илүү их хувийг эзэлж байна.
2. Тухайн бүс нутагт ажилгүйдлийн түвшин өндөр, ажиллагсад болон ажилгүйчүүдийн боловсролын түвшин доогуур байгаа нь шилжих хөдөлгөөн үүсэх шалтгаан болж байна. Иймд тухайн боловсрол багатай хэсэг рүү хандсан ажлын чиг баримжаа олгох сургалт зохион байгуулж ажилгүйчүүдийг ажиллагсдын эгнээнд шилжүүлэх нь шилжилт хөдөлгөөнийг бууруулах томоохон арга хэрэгсэл болно.
3. Хөдөө аж ахуйн салбар болон энгийн ажил гүйцэтгэгчид, үйлчилгээний ажилчид нийт ажиллагсдын ихэнх хувь, хэмжээг эзэлж байна. Энэ нь тухайн бүс нутгийн ажлын байрны онцлог (шинээр шинэ мэргэжлийн ажлын байр бий болох боломж)-той холбоотой боловч тэдний авч буй цалин хөлс бусад салбарт ажиллагсдын цалингийн түвшнээс харьцангуй доогуур байгаа нь тухайн бүс, нутгийн хүн амын амьжиргаагаа сайжруулах зорилгоор шилжих хөдөлгөөнд оролцох шалтгаан болж байна гэж үзэх үндэслэлтэй. Мөн шилжигсдийн дийлэнх ирдэг Улаанбаатар хотод дээр авч үзсэн мэргэжилтнүүдийн авч буй цалин харьцангуй өндөр байгаа нь шилжих хөдөлгөөний нэг шалтгаан болж байна.
4. Үүнээс гадна ажиллагсдыг байгууллагын өмчийн хэлбэрээр авч үзэхэд ихэнх хувь нь хувийн хэвшилд ажиллаж байна. Тиймээс хөдөөд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, уг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого баримтлах нь зүйтэй юм. Үүгээр дамжуулж ажлын байрыг нэмэгдүүлж, улмаар шилжих хөдөлгөөн сааруулах боломж, нөхцөлийг бүрдүүлж болно.
5. Орчин үеийн мэргэжилтэй, боловсрол өндөртэй мэргэжилтний ажлын байр байхгүй учраас тэд хот суурин газрыг зорьдог. Үүнээс гадна боловсролтой ажилчид дотроос ажлын ур чадвар, мэдлэг өндөртэй хэсэг нь Улаанбаатар хотыг зорьдог. Иймд хөдөө орон нутагт тэр дундаа

хөдөөгийн чадварлаг ажиллах хүчнийг тухайн бүс нутагт ажиллуулахад төрийн бодлогыг чиглүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Тиймээс баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрт “Бүс нутагт хүн ам суурьшуулах зорилго бүхий урамшууллын бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвор суурьшлийг сайжруулах арга хэмжээ авах” талаарх бодлогыг тусгажээ. Энэ хөтөлбөрийг хэргэгжүүлбэл өндөр боловсролтой ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг хангаж чадна.

Ашигласан ном зүй

1. Б.Бүжинлхам, Санхүүгийн удирдлага, СЭЗДС, 2004 он, УБ
2. Хөдөлмөрийн эдийн засаг, Хөдөлмөрийн дээд сургууль, 2006 он, УБ
3. Ronald G.Ehrenberg, Robert S.Smith, Modern labor economics, 8th, ed
4. Michael P.Todaro, Stephen C.Smith, Economic development, 8th, ed
5. Debraj Ray, Development Economics
6. ҮСГ-ын жил бүрийн эмхэтгэлүүд
7. Баруун бүсийн хүн ам зүйн орчны судалгаа 2006 он. МУИС-ийн Завхан дахь ЭЗСС
8. Хүний хөгжил, 2006 он, Улаанбаатар хот
9. Монголын хүний хөгжлийн илтгэл 2007 он.
10. Хүн ам зүйн үндсэн асуудлууд, МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Ам Сургалт Судалгааны Төв, Улаанбаатар 2006 он
11. Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр (2005-2016 он), Улаанбаатар хот 2006 он.
12. С.Даваасүрэн, Хөгжлийн эдийн засаг, 2002, УБ
13. Боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан технологийн салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл, (2002-2003 оны хичээлийн жилд), БСШУЯ
14. Боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан технологийн салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл, 2004 он, БСШУЯ
15. www.google.mn
16. Donald E. Pursell, Determinants of Male Labor Mobility, Demography, Vol. 9, No. 2. (May, 1972), pp. 257-261

Хавсралт 1. Шилжих хөдөлгөөнийг хүний “Нэг хүнд ногдох ДНБ-ий (валютын худалдан авах чадварын паритет, ам.доллар) индекс”-тэй харьцуулан судлах нь



Хавсралт 2. Шилжилт хөдөлгөөн ба ажиллах хүчний өртгийн хамаарлын шинжилгээ



Хавсралт 3. Эконометрик үнэлгээ

Dependent Variable: Y
 Method: Panel EGLS (Cross-section weights)
 Date: 02/13/09 Time: 07:15
 Sample: 2001 2007
 Cross-sections included: 5
 Total panel (balanced) observations: 35
 Linear estimation after one-step weighting matrix
 Cross-section weights (PCSE) standard errors & covariance (d.f. corrected)

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
X1	8925.100	2716.576	-3.285422	0.0025
X2	19651.63	1978.264	9.933776	0.0000
X3	19525.34	2044.722	-9.549140	0.0000

Weighted Statistics

R-squared	0.610906	Mean dependent var	1566.879
Adjusted R-squared	0.586587	S.D. dependent var	1343.024
S.E. of regression	863.5262	Sum squared resid	23861678
Durbin-Watson stat	1.927932		

Unweighted Statistics

R-squared	0.552653	Mean dependent var	1518.057
Sum squared resid	28622050	Durbin-Watson stat	1.796257